



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/54

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөөс өөрийн аймагтаа өвөлжиж байгаа малчин өрхүүдэд хямдралтай үнээр олгох өвсний хуваарь болон тээврийн зардлыг нэгдүгээр, Булган аймгийн Баяннуур, Бүрэгхангай, Дашинчилэн, Рашаант сумдад оторлож байгаа малчин өрхүүдэд болон Баянгол, Богд, Сант, Төгрөг, Гучин-Ус сумдад тус бүр 30 тонн хүчит тэжээл хүргэх автомашины тээврийн хөлс, ажлын хэсгийн шатахууны зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хавсралтанд тусгагдсан 31,405,952 (гучин нэгэн сая дөрвөн зуун таван мянга есөн зуун тавин хоёр) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

3.Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөөс сумдад хямдралтай үнээр олгож байгаа өвсний үнийг аймгийн Засаг даргын Тамгын газрын 100100051416 тоот данс (РД 9044051) буцаан төвлөрүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг даалгасугай.

4.Сумдад өвс хуваарилах ажлыг зохион байгуулах, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ


011100126

Аймгийн Засаг даргын 2021 оны 028 дугаар сарын 02-ны өдрийн 4154 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ХЯМДРАЛТАЙ ҮНЭЭР ОЛГОХ ӨВС
БОЛОН ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

д/д	Сумын нэр	Гадны аймагт оторлоогүй малчин өрх	Малчин өрх бүрт 3 боодол хямдралтай үнээр олгох өвс /ширхэг/	Сумдад хямдралтай үнээр олгох өвсний үнэ /нэг бүрийн үнэ 8000 мянган төгрөг/	Сумд өөрийн зардлаар татан авах өвсний тоо	Аймаг өөрийн зардлаар сумдад хүргэх өвсний тоо	Аймгаас гарах өвсний тээврийн зардал /мянган төгрөг/
1	Баян-Өндөр	603	1800	14400.0	900	900	1260.0
2	Бүрд	557	1650	13200.0	810	840	0.0
3	Бат-Өлзий	1267	3800	30400.0	1900	1900	2280.0
4	Баруунбаян-Улаан	499	1500	12000.0	750	750	1500.0
5	Баянгол	548	1600	12800.0	800	800	720.0
6	Гучин-Ус	290	870	6960.0	435	435	435.0
7	Есөн-зүйл	614	1850	14800.0	600	1250	0.0
8	Өлзийт	489	1450	11600.0	725	725	725.0
9	Зүүнбаян-Улаан	1064	3200	25600.0	1600	1600	800.0
10	Богд	1036	3100	24800.0	1550	1550	3255.0
11	Нарийнтээл	619	1850	14800.0	925	925	1295.0
12	Сант	565	1700	13600.0	850	850	850.0
13	Тарагт	787	2350	18800.0	1175	1175	4112.5
14	Төгрөг	438	1300	10400.0	650	650	650.0
15	Уянга	1667	5000	40000.0	2500	2500	1750.0
16	Хайрхандулаан	796	2400	19200.0	1200	1200	840.0
17	Хужирт	895	2700	21600.0	1350	1350	1350.0
18	Хархорин	1076	3250	26000.0	1625	1625	2275.0
19	Арвайхээр	621	1850	14800.0	1850	0	0.0
		14431	43220	345760.0	22195	21025.0	24097.5

Аймгийн Засаг даргын 2021 оны... дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралт



ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Арга хэмжээний нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /мянган төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/	Тайлбар
1.	Дашинчилэн, Баяннуур, Рашаант, Бүрэгхангай, сумдад тус аймгаас оторлож буй малчдад хүчит тэжээл хүргэх	29.76 тонн	0.180	1,419,552	Нийт тонн*180төгрөг* явсан км=тээврийн зардал
2.	Баянгол, Богд, Сант, Төгрөг, Гучин-Ус тус бүр 30 тонн хүчит тэжээл хүргэсэн тээврийн зардал	150 тонн		4,876,000	
3.	Гадны аймагт оторлож байгаа малчин өрхүүдэд хүчит тэжээл тараах ажлын хэсгийн шатахууны зардал			704,900	
4.	Булган аймгийн Бүрэгхангай Баяннуур сумдад аймгийн отрын малчдын адууг хөөсөн, алдсан адууны эрлээр Цагдаагийн газраас ажлын хэсгийн бие бүрэлдэхүүн ажилласан шатахууны зардал			308,000	
	Нийт			7,308,452	